



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.01.22 № 05/962  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан Т мэдүүлэг хянасан тухай Г

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дагвын Дөлгөөний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.


Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагад "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх, төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан" байхаар заасныг нэр дэвшигч Д.Дөлгөөн нь хангаагүй, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх", 43.6-д "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд тухайн албан тушаалд ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага болон Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн этгээдийн нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

Хувийг: Төрийн албаны зөвлөлд.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Л.СҮХ-ОЧИР



0002961